

**2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2024 оны 04 дүгээр сарын 10-ны “Лхагва” гарагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
1	Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгаврын худалдан авах ажиллагааг зохион байгуулах байгууллагуудад хүргүүлж, ажлаа эрчимжүүлж ажиллах.	ХААА
2	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжийн дагуу Хаврын их цэвэрлэгээг 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 19-ний өдрүүдэд зохион байгуулах. (Их цэвэрлэгээг зохион байгуулахтай холбогдуулан ил гарсан цахилгааны утсыг цэгцлэх ажлыг зохион байгуулж, аюулгүй байдлыг хангах хүрээнд хуваарь гарган шалгалтыг 2024.04.05-ны өдөр зохион байгуулах.)	ТХҮХ, Нийт байгууллагууд
3	Нийтийн эзэмшлийн зам талбай дээр байгаа эд зүйлсийг ачих тухай захирамжийг гаргаж, зохион байгуулах.	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс, ГЗБА
4	Бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор барилгын зөвшөөрөл, газрын зөвшөөрлийг олгож, барилгын салбарын болон худалдаа үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзах уулзалтад идэвхтэй хамрагдах.	Нийт байгууллагууд
5	Дүүргийн хэмжээнд эвдэрч гэмтсэн зам талбай болон явган хүний замын тооцоо, судалгааг гаргаж, засварлах, сайжруулах ажлын төлөвлөгөө, төсөв тооцоог гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	2024 оны төсөвт өөрчлөлт орсонтой холбогдуулан хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд БҮТП ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор нийслэлийн төсвөөс санхүүжилт шийдвэрлэгдсэн ажлын гүйцэтгэгч ХХК-тай холбогдон, шаардлагатай бусад ажлуудаа эрчимжүүлэн ажиллах.	БҮТП
7	2024 оны Тохижилтын ажлын төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан байгууллагууд хэрэгжилтийг хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, Нийт байгууллагууд
8	Хүүхэд, багачууд, оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заал болон бусад спортын талбайг нээлттэй болгох, 2 дугаар хорооны Хөл бөмбөгийн талбайн хяналтыг сайжруулан эвдрэл гэмтлийг засварлах.	НХХ, БТСХ “Хангай” цогцолбор сургууль
9	Замын хөдөлгөөний ачаалал ихэсч байгаатай холбогдуулан иргэдийг зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх уриалга гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
10	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд эвдэрч гэмтсэн	Багахангай тохижилт,

	гэрлийн шон, авто замын тэмдэг, тэмдэглэгээ, тоглоомын талбай, хайс хашлагыг засварлах угаах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд
11	Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүд 50м хүртэлх талбайгаа цэвэрлэх, эвдэрч гэмтсэн хайс хашаа, хаяг реклам самбар зэргийг засварлах угаах ажлуудыг зохион байгуулах.	Нийт байгууллагууд
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
12	2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар дүүргийн үйл ажиллагаатай танилцахаар хүрэлцэн ирэх тул бэлтгэлийг сайтар ханган ажиллах.	Нийт байгууллагууд
13	Дүүргийн 1 дүгээр хорооны орон сууцны байрнуудын орцны засварын ажил үргэлжлэн гүйцэтгэгдэж байгаа тул иргэд, оршин суугчдад зөвөөр ойлгуулж, СӨХ-г тус ажилд идэвхжүүлэх. (Хаалганы кодыг чипээр солих, чипийг оршин суугчдад тараах ажлын зохион байгуулалт хийх)	ТХҮХ, СӨХ
14	Дүүргийн 2024 оны зорилтот жилийн хүрээнд хийгдэх "Фокус бүлгийн уулзалт"-д идэвхтэй оролцох.	Нийт байгууллагууд
15	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх дүүргийн Хууль сахиулах байгууллагуудын бэлтгэл сургуулилтын талбайн ажлын талаар холбогдох байгууллагуудтай уялдаатай ажиллах.	ОБХ
16	Дүүргийн 2 дугаар хорооны СӨХ-ны хурлыг зохион байгуулах.	ТХҮХ, 2 дугаар хороо
17	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд дүүрэгт шилжин ирээгүй ажилтан, албан хаагчдын судалгааг гарган 2024.04.03-ны өдрийн 15:00 цагаас өмнө Засаг даргын туслах (ERP-М.Батсайхан)-д ирүүлэх.	Нийт байгууллагууд
18	Иргэний бүртгэлтэй холбоотой зөрчлийг бууруулах, зөрчил гаргахгүй байх, бууруулах талаарх урьдчилсан арга хэмжээг зохион байгуулах.	Усын бүртгэлийн хэлтэс, Хороод
19	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудыг яаралтай эхлүүлэх.	НХХ, БТСХ, Соёлын ордон
20	Газар олголттой холбоотой асуудлуудыг цэгцлэх.	ГЗБА
21	Нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэх ажлаа эрчимжүүлэх.	Татварын хэлтэс
22	Хөрөнгө оруулалтын ажил бүрийг хүлээн авах Ажлын хэсэг томилох.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР